14. Хувь хүний нууц халдашгүй байх эрх

63. УИХ-аас 1995 онд "Хувь хүний нууцын тухай хууль"-ийг батлан гаргасан бөгөөд "Хувь хүний нууц" гэж Монгол Улсын иргэн, гадаадын хүн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ, гэж тодорхойлсноос гадна хувь хүний нууцын төрөл, хамгаалах баталгаа, хувь хүний нууцын талаар шүүхэд гомдол гаргах эрх зэргийг хуульчилсан.

64. Хувь хүний нууцыг хамгаалах зорилгоор шүүх хуралдааныг хаалттай явуулж болох тухай өөрчлөлтийг 2007 онд ЭБШХ-д оруулсан бөгөөд мөн ХЭТТ-д нийцүүлэн иргэний захидал, харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчсөн, энэ хэргийг албан тушаалын байдлаа урвуулж буюу хэтрүүлж, эсхүл тусгай техник хэрэгсэл ашиглаж үйлдсэн хэрэгт ял шийтгэхээр, түүнчлэн хуулиар хамгаалагдсан хувь хүний мэдээллийг задруулсан, олон нийтэд тараасны улмаас бусдад хүнд хор уршиг учирсан бол ял шийтгэхээр тус тус нэмэлт, өөрчлөлтийг Эрүүгийн хуулинд 2008 онд оруулсан.